



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

2023

Эрхэм зорилго

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Хэтийн зорилт

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.



Агуулга

Танилцуулга

Байгаль орчин

Нийгэм

Засаглал

Тогтвортой хөгжлийн тайлангийн тухай



Бид 2023 оны Тогтвортой хөгжлийн жилийн тайлангаараа дамжуулж ХасБанкнаас хэрэгжүүлсэн санхүүгийн бус олон талт үйл ажиллагааны стратеги, тогтвортой хөгжлийн санаачилга, үр дүн, ололт амжилтыг тайлагнаж байна. Энэхүү тайлан нь Даян дэлхийн ил тод тайлагнал (GRI), Тогтвортой хөгжлийн нягтлан бодох стандартын зөвлөлийн (SASB) стандартууд, Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсэг (TCFD) зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн удирдамжуудын шаардлагыг хангасан болно. Тогтвортой хөгжлийн талаар хийсэн ажлаа тайлагнаснаар бид Нэгдсэн Үндэсний Байгууллагын Даян дэлхийн тогтвортой хөгжлийн зарчим, ил тод байдал, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаанд тууштай байгаагаа нотлон харуулж байна.

Тайлбар толь

Баталгаажсан Хүлэмжийн Хийн Ялгаралтын Бууруулалт (БХХЯБ)

Китогийн Протоколын Цэвэр Хөгжлийн Механизмын (ЦХМ) дагуу баталгаажсан хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах энэ нэгж нь ялгаруулалтыг тоон хэмжээгээр бууруулж байгааг харуулдаг.

Компанийн Нийгмийн Хариуцлага (КНХ)

Бизнесийн үйл ажиллагаа нь санхүүгийн зүгээс гадна нийгэм, байгаль орчин, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг харгалзан ёс зүйтэй, хариуцлагатай байх.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)

Зах зээлд суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, шилжилтийн шатанд байгаа улс орнуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмждэг олон улсын санхүүгийн байгууллага.

Эрчим хүчний хэмнэлт (ЭХХ)

Эрчим хүчний хэрэглээг багасгахад чиглэсэн тодорхой ажлыг гүйцэтгэх эсвэл тодорхой бүтээгдэхүүнийг хэрэглэхэд эрчим хүчийг хэр хэмнэлттэй зарцуулж байгааг хэмжих хэмжүүр.

FMO

Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани нь хөгжиж буй зах зээлд хувийн хэвшлийн тогтвортой хөгжлийг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлдэг байгуулга юм.

Уур амьсгалын ногоон сан (УАНС)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын (UNFCCC) дагуу хөгжиж буй орнуудад уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх төсөл, хөтөлбөр, бодлого, бусад үйл ажиллагааг дэмжих санхүүгийн механизм.

Хүлэмжийн хий (ХХ)

Нүүрстөрөгчийн давхар исэл, метан зэрэг хий нь дэлхийн агаар мандалд дулааныг барьж, хүлэмжийн орчин байгуулж, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг.

Дэлхийн Ил Тод Тайлагнал (ДИТТ)

Байгууллагуудыг эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр дүнг хэмжих, тайлагнах удирдамжаар хангадаг тогтвортой хөгжлийн тайлагналын өргөн хэрэглэгддэг тогтолцоо.

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)

Хөгжиж буй орнуудын хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Дэлхийн Банкны Группийн гишүүн.

Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартууд (СТОУС)

Санхүүгийн тайланг бэлтгэх, дэлхийн хэмжээнд санхүүгийн тайлангийн уялдаа холбоо, харьцуулалтыг хангах үйл ажиллагааг зохицуулдаг олон улсын нягтлан бодох бүртгэлийн багц стандартууд.

Бичил, жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)

Бичил, жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) нь ажиллах хүчний хязгаарлагдмал онцлогтой аж ахуйн нэгж юм. 10-аас цөөн ажилтантай бол бичил үйлдвэр, 50 хүртэлх ажилтантай бол жижиг үйлдвэр, 250 хүртэлх ажилтантай бол дунд үйлдвэр гэж ангилна.

Нийгэм, байгаль орчны менежментийн систем (НБОМС)

Шийдвэр гаргах үйл явц, үйл ажиллагаанд нийгэм, байгаль орчны асуудлыг нэгтгэх, удирдахад чиглэсэн банкны бүтэц зохион байгуулалтын тогтолцоо.

Тогтвортой хөгжлийн нягтлан бодох стандартын зөвлөлийн (ТХНБЗ) стандартууд

Компаниуд санхүүгийн хувьд материаллаг тогтвортой байдлын талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад ил болгох тусгай стандартууд.

Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсэг (УАХСАХ)

Жил бүрийн санхүүгийн тайландаа уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэл, боломжуудыг ил тод болгох зөвлөмжийг компаниудад өгдөг олон улсын тогтолцоо.

Сайн дурын хүлэмжийн хийн ялгаруулалтын бууруулалт. (СДХХЯБ)

Зохицуулалтын шаардлагаас гадуур бууруулсан хүлэмжийн хийн баталгаажуулсан ялгаруулалт, бөгөөд ихэвчлэн сайн дурын нүүрстөрөгчийн зах зээлд ашиглагддаг.

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон ажилтнууддаа,

Энэхүү захидлаа би, биднийг дэмжигчид болох Төлөөлөн Удирдах Зөвлөл, Хувьцаа эзэмшигчид, Удирдлагын баг, ХасБанкны 1,300 ажилтан болон олон улсын түншүүддээ талархаж байгаагаар эхлүүлж байна. Та бүхний дэмжлэгтэйгээр ХасБанк нь нийгэм, байгаль орчны үнэт зүйлсийг бизнесийн стратеги, үйл ажиллагаа, зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн бүтээгдэхүүндээ амжилттай нэгтгэж ирсэн билээ. ХасБанкны хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа, тогтвортой өсөлтийн үйл ажиллагааны зарчмыг тууштай барин ажиллаж буй чухал үе шатуудыг онцолсон анхны Тогтвортой хөгжлийн тайлангаа та бүхэнд бахархалтайгаар танилцуулж байгаадаа баяртай байна. Энэхүү захидалдаа би тогтвортой эдийн засагт шилжих үйл явцыг манлайлах үүргээ улам амжилттай болгохын тулд олон жилийн турш хэрэгжүүлж буй байгаль орчин, нийгмийн гол санаачилгын ахиц дэвшил, мөн 2024 оны төлөвлөгөөний талаар хуваалцах болно.

ХасБанкны үйл ажиллагаа анх 2001 онд Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн 1 сая ам.долларын бичил санхүүгийн төслөөс эхэлж байсан түүхтэй. ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашиг гэсэн хөгжлийн гурван үндсэн тулгуураа тууштай баримталж ирсэн.

Эрдэнэт хүмүүн: Өнөөдрийн байдлаар бид 1 сая гаруй харилцагчдад 70 гаруй салбар нэгжээр банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлж, олон улсын 50 гаруй байгууллагатай үүсгэсэн түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж байна. Бид өөрсдийн бизнесээс гадна нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмэр оруулж, ажилтнуудынхаа эрүүл мэнд, сайн сайхан оршихуйд анхаарч ажилладаг. Бид 2003 онд Монгол Улсын ирээдүй хойч үеийнхэнд санхүүгийн мэдлэг олгох сургалт, боловсролын тогтолцоо болон бусад хандивын үйлсийг дэмжих зорилгоор Хөгжлийн Алтан Сан холбоо ТББ-ыг үүсгэн байгуулсан. Өнгөрсөн хугацаанд тус ТББ-ын үе үеийн ХасБанкны ажилтан гишүүдийн оролцогоор 815 сая төгрөгийн санхүүжилт бүхий хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн 100,000 илүүтэй хүмүүст хүрч ажилласан. Банкны ажилтнуудад зориулан орон сууцны зээлийн хөтөлбөр, тэтгэврийн данс, эрүүл мэндийн үзлэг, нэмэлт амралт зэрэг ажилтнуудынхаа сэтгэл санаа, бие бялдрын эрүүл мэндэд анхаарч тэдгээрийг тэнцвэртэй авч явахад туслах олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Эх дэлхий: Санхүүгийн байгууллагын хувьд бид тогтвортой хөгжлийг төгөлдөржүүлэх үүргээ бүрэн дүүрэн ухамсарлан ойлгож байгаа. Нэгэн тэмдэглүүштэй хамтын ажиллагаа бидэнд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх шинэлэг, үр дүнтэй санаачилгыг хэрэгжүүлэх боломжийг олгосон юм. Бид 2016 онд Уур амьсгалын ногоон сангаас (GCF) магадлан итгэмжлэл авсан хөгжиж буй орнуудын анхны арилжааны банк бөгөөд дэлхийн хамгийн анхны хувийн хэвшлийн Уур амьсгалын ногоон сангийн магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсон. Бид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд 2022 онд мөн дахин магадлан итгэмжлэгдсэн. Түүнчлэн бид дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст нүүрстөрөгчийн хий арилжсан анхны арилжааны банк болсон томоохон амжилтаар Монгол Улсын санхүүгийн салбарт шинэ санаачилгыг түүчээлэн манлайлагч нь болсон билээ. Бидний хөрөнгө оруулалт нь жижиг бизнес эрхлэгчид болон тэр дундаа гэр хорооллын иргэдэд зориулсан сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэц, эрчим хүчний хэмнэлттэй зээлийн бүтээгдэхүүн зэрэг тогтвортой санхүүжилтийн олон төрөлд чиглэдэг. 2013 оноос хойш бид ногоон санхүүжилтийн үйл ажиллагааны үр дүнд нийт 2,543,880 тонн CO2 ялгаралтыг бууруулаад байна.

Эрүүл ашиг: ХасБанк нь 2023 оны 6 дугаар сард IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон ба түүнээс хойш ХасБанкны ашиг, өсөлт, бизнесийн боломжууд гайхалтай өслөө. ХасБанк нь жижиг, дунд бизнесийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дотоодын оролцогч талуудтай хамтран ажиллах замаар нийгэмд хүртээмжтэй эдийн засгийн хөгжлийг хангахын төлөө ажилладаг.

Хөгжил дэвшил

Өнгөрсөн жилийн хувьд бид тогтвортой хөгжлийн зарчмыг бизнесийн загвартаа суулгаж өгөх ажилд ахиц дэвшил гаргалаа. Бид үйл ажиллагааныхаа хүрээнд хоёр салбар болон төв байрандаа 10 кВт/цагийн хүчин чадалтай нарны цахилгаан панел (PV)-ийн системийг суурилуулж, ус, эрчим хүчний хэрэглээгээ хянаж, мөн хог хаягдлаа ангилах ажлыг хэрэгжүүлсэн. Бид уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг удирдах засаглалын бүтцийг бий болгож, Парисын хэлэлцээрт нийцүүлэн уур амьсгалын эрсдэлийн шилжилтийн төлөвлөгөөгөө боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлууллаа. Цаашид бид хөрөнгө оруулалт болон Монгол Улсын эдийн засагт тогтвортой хөгжлийг бий болгохын тулд олон улсын агентлагууд, банкны салбарын түншүүд, зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн бэхжүүлэх болно.

Ирээдүй

Бид хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд алсын хараа, стратеги, үйл ажиллагаандаа дасан зохицох чадвартай, шинэлэг хэвээр байх болно. Цаашид бизнесийн загвар маань энгийн байх нь хангалтгүй болж байна. Тиймээс Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь биднээс анхаарал хандуулах, зоримог арга хэмжээ авахыг шаардаж байна. Хариуцлагатай санхүүгийн байгууллагын хувьд бид нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах өөрсдийн үүрэг хувь нэмрээ сайн ойлгож, энэхүү тайланд дэлгэрэнгүй дурдсан ололт амжилтыг тэмдэглэхийн хэрээр бид илүү их амжилтанд хүрэхийг зорин ажиллаж байна. Та бид хамтдаа хойч үедээ тогтвортой, сайхан ирээдүйг бий болгохын тулд санхүүгийн хөшүүргийг бий болгох хүч чадалтай билээ.

**ХасБанкны
Гүйцэтгэх захирал
Гүмэнжавын ЦЭВЭГЖАВ**







2001

- Монголбанкны ерөнхийлөгчөөс арилжааны банк нэрээр үйл ажиллагаагаа эрхлэх лиценз гардаг авсан анхны ББСБ болов.

2002

- ISO14001 стандартад нийцсэн Нийгэм, байгаль орчны удирдлагын бодлогоо анхлан баталсан.
- Хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн бат бэх суурийг бий болгоход эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын хүүхдүүдэд зориулсан анхны урт хугацаат хуримтлалын бүтээгдэхүүн “Ирээдүйн саятан”-хадгаламжийг гаргасан.

2003

- Хөгжлийн Алтан Сан Холбоо нэрээр бие даасан ТББ байгуулж, нийгмийн сайн сайхны төлөө хөрөнгө оруулалтын сан үүсгэв.
- Байгууллагын хувьцааг ажилтнуудад эзэмшүүлэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн хамгийн анхны банк болов.

2004

- Бичил санхүүгийн үнэлгээний тэргүүлэгч “Planet Rating” агентлаг газар дээр нь ирж үнэлгээ хийж, ХасБанканд “А-” үнэлгээ өгсөнөөр олон улсын үнэлгээний агентлагаар үнэлгээ хийлгүүлсэн Монголын анхны банк болов.
- Банк нь санхүүгийн тайлангийн ил тод байдлыг өндөр түвшинд хангасан тул Дэлхийн банкны Ядуу өрхөд туслах зөвлөлийн бүлэг (CGAP)-ээс хамгийн өндөр үнэлгээг авч, “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдав.

2005

- НҮБ-ын Олон улсын бичил зээлийн жилийн хүрээнд ХасБанк нь алслагдсан бүс нутгийн иргэдэд санхүүгийн цогц үйлчилгээг хүргэх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс өөрсдийн үйл ажиллагаагаа эрчимтэй өргөжүүлж 72 сумдад шинээр хүрч ажилласан бөгөөд мобайл банкны үйлчилгээнд хамрагдсан сумдын тоог нийт 165 болгож нэмэгдүүлэв.
- НҮБ-ын Бичил зээлийн жилийн хүрээнд зохион байгуулсан “Оны шинэлэг бичил санхүүгийн бүтээгдэхүүн” шагнал гардуулах ёслолын үеэр ХасБанкны “Хөгжлийн хөтөч” франчайзингийн үйлчилгээ нь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн (UNDP) Дэлхийн бичил бизнес эрхлэгчдийн шагналыг (GMA) хүртэв. Түүнчлэн Дэлхийн банкны Ядуу өрхөд туслах зөвлөлийн бүлэг (CGAP)-ээс энэхүү төслийг цаашид хөгжүүлэх зорилгоор ХасБанканд “ProPoor Innovation Challenge” тэтгэлэг олгов.

2006

- Бүтэн цагийн багш, шаардлагатай тоног төхөөрөмж бүхий цогцсургалтын төв нээгдсэн ба уг сургалтын төв нь ХасБанкны ажилтнуудад банк санхүү, харилцааны ур чадвар, менежмент, манлайлах ур чадвар болон англи хэлний мэдлэг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.
- Банкны худалдан авалтын бодлого процессыг шинэчилж, нийлүүлэгч, гэрээлэгч нарт тавигдах ил тод нээлттэй, өрсөлдөөнт худалдан авалтын шаардлагуудыг тодорхойлж, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэлтэнд дагаж мөрддөг болсон.
- “Planet Rating”-ын бичил санхүүгийн үнэлгээний байгууллага нь ХасБанкны үнэлгээг ахиулж “А” гэж үнэлэв.
- Дэлхийн банкны Ядуу өрхөд туслах зөвлөлийн бүлгийн (CGAP) Санхүүгийн ил тод байдлын шагналыг гурав дахь удаагаа хүртэв.

2007

- Корпорацийн ил тод байдал, корпорацийн нийгмийн хариуцлагын менежментийг сайжруулахын тулд Даян дэлхийн ил тод тайлагнал (GRI) болон НҮБ-ийн Даян дэлхийн гэрээнд нэгдэв.

2008

- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, МҮХАҮТ-тай хамтран Үндэсний хөгжлийн санхүүжилтийн анхдугаар чуулганыг зохион байгуулсан. Тус чуулганаар дэлхийн санхүүгийн манлайлагчдыг цуглуулж, салбарын шилдэг туршлага, нийгэмд үзүүлэх нөлөөллийг оновчтой болгох арга замын талаар хэлэлцэв.
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк болон Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран ажиллаж, алслагдсан бүс нутгийн бага орлоготой эмэгтэйчүүдийг дэмжих бүлгийн зээлийн хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн.
- Олон нийтэд танигдсан нэр хүнд бүхий хүмүүсээс бүрдсэн “Олон нийтийн зөвлөлдөх хороо”-г байгуулав.

2009

- FMO банкаас 6.5 тэрбум төгрөгийн синдикат зээл авч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний хэрэглээний зээлийг 1788 иргэнд олгосон.
- ХасБанк нь “MicroEnergy Credits” (“MEC”) байгууллагаар дамжуулан нүүрстөрөгчийг санхүүжилт хийх боломжийг бүрдүүлсэн бөгөөд улмаар хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг карбоны сайн дурын зах зээлд арилжаалж, карбоны нөхөн төлбөрийн санхүүжилт авсан бөмбөрцөгийн хойд хэсэгт байрших анхны бичил санхүүгийн банк болов.
- Экобанкны нэгжийг байгуулж, тус нэгжнь Нидерландын Хөгжлийн Агентлагийн эрчим хүчний хэмнэлтийн сангийн тусламжтайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд MicroEnergy Credits (“MEC”)-ээр дамжуулан карбоны бууралтыг борлуулж орлогоо нэмэгдүүлснээр үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэв.
- Бага орлоготой иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй хүү бүхий зээлийн санхүүжүүлээр худалдан авах боломжтой “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн түгээх хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлсэн. ХасБанк нь “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн түгээх хөтөлбөр”-ийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг түлшний зардлаа бууруулж, илүү цэвэр агаар амьсгалж, өвлийн урт саруудад дулаан байх боломжийг бий болгов.
- ХасБанк нь Дэлхийн Эмэгтэйчүүдийн Банк (WWB) болон Олон улсын боломж байгууллагын тусламжтайгаар залуу үеийн санхүүгийн боловсролыг дэмжихэд чиглэсэн “Охидын боловсрол” хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэхүү санаачилгын хүрээнд Банк нь “Тэмүүлэл” нэртэй охидын хадгаламжийн шинэ бүтээгдэхүүнийг гаргав.

2010

- “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн түгээх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, борлуулалтын цэгүүдээрээ дамжуулан гэр хорооллын айл өрхийн 80 орчим хувьд эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэйгээр худалдан авах боломжийг бүрдүүлэв.
- ХасБанк нь өөрийн нийгмийн хариуцлагын хэрэгжилтэндээ дэлхийн бичил санхүүгийн үнэлгээний тэргүүлэгч байгууллага болох “Планет рейтинг” байгууллагаар үнэлгээ хийлгүүлж өндөр үнэлгээ авсанаар дэлхийн шилдэг нийгмийн хариуцлагатай санхүүгийн байгууллагуудын нэг болж шалгарав.
- ХасБанк нь нийгмийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайлангийн төрөлд Дэлхийн банкны Ядуу өрхөд туслах зөвлөлийн бүлгээс (CGAP) хоёр дахь жилдээ Мөнгөн медаль шагнал хүртэж, Нийгмийн хариуцлагатай банкны тэргүүлэгч байр сууриа бататгав. Ийнхүү тус байгууллагаас бидний амжилтыг хүлээн зөвшөөрсөн нь ХасБанкны харилцагчдынхаа амьдралд үзүүлж буй нөлөөллийг ил тод тайлагнаж, хариуцлагатай байх амлалтандаа хүрч байгааг үнэлсэн явдал байлаа.

2011

- ХасБанк нь Испани Улсад зохион байгуулагдсан Дэлхийн бичил зээлийн чуулга уулзалтаас хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсны нөхөн төлбөрийг хүлээн авсан нь дэлхийн хамгийн анхны тохиолдол болсон юм.
- ХасБанкны толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл нь Компанийн засаглалын ёс зүйн дүрмийг баталж, ХасБанк болон бусад групп компаниудын дагаж мөрдөх компанийн засаглалын зарчмуудыг дахин баталгаажуулав.

2012

- Монгол Улс дахь анхны мобайл банкны аппликейшнийг хөгжүүлэв.
- “Service Excellence” төслийг хэрэгжүүлж, тус төслийн стандартыг хангасан Монгол Улсын анхны банк болов.
- Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны сан (GCPF)-аас тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалтаар 20 сая ам.долларын санхүүжилт татсан.

2013

- ЕСБХБ-аас 10 сая ам.долларын Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилтийн Сан (MonSEFF)-ийг хүлээн авав.
- Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийг зах зээлд анхлан нэвтрүүлэв.
- Хүлэмжийн хий ялгаруулалтын баталгаажсан бууралтыг (ХХЯББ) арилжаалах зорилгоор Цэвэр хөгжлийн механизмд бүртгүүлэв.

2014

- ХасБанкны нийгмийн үйл ажиллагааг “Планет Рейтинг” бичил санхүүгийн үнэлгээний байгууллага Ази тивээс хамгийн өндөр “4” буюу “Хангалттай” үнэлгээг өгч нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөллийг нь баталгаажууллаа. Олон улсын түвшинд ХасБанк нь “Планет Рейтинг” агентлагаар Нийгмийн төлөө хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үнэлгээгээ хийлгүүлсэн Шилдэг 15 байгууллагын нэг болсон.
- “responsAbility” байгууллагатай хамтран ажиллаж, харилцагчиддаа зориулан хосолсон хөдөлгүүрт автомашин худалдан авах Эко машины зээлийн хөтөлбөрийг эхлүүлэв. 2018 оны эцэс гэхэд тус хөтөлбөрийн хүрээнд 1067 харилцагчдад 5.2 сая гаруй ам.доллартай тэнцэх санхүүжилтийг олгосон байна.

2015

- ХасБанкны үйл ажиллагааг Франц Улсад төвтэй олон улсад нэр хүнд бүхий бичил санхүү, нийгмийн үнэлгээний агентлаг болон Планет Рейтинг үнэлж, 2015 оны 8 дугаар сард дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Харилцагчийг хамгаалах зарчмуудыг амжилттай хэрэгжүүлсэн, өндөр амжилт гаргасныг баталгаажуулж тул Харилцагчийг хамгаалах ухаалаг хөдөлгөөний гэрчилгээг гардуулав.
- Хүлэмжийн хийн ялгаруулалтын баталгаажсан бууралт (ХХЯББ)-ын кредитийг Шведийн Засгийн газарт худалдах гэрээ байгуулав.

2016

- ХасБанк нь Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гаар магадлан итгэмжлэгдсэн хөгжиж буй орны анхны хувийн хэвшлийн байгууллага болов.

2017

- Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор УАНС-гаас 19.5 сая ам.долларын зээлийн санхүүжилт, 0.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилт авав.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, УАНС-тай хамтран “Боломжийг бодит болгоё” уриан дор Ногоон санхүүжилтийн анхдугаар чуулганыг зохион байгуулав.
- ХасБанкны Сэргээгдэх эрчим хүчний төслийг санхүүжүүлэх санал нь УАНС-гаар батлагдсанаар бид арилжааны зориулалттай сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станцыг санхүүжүүлсэн Монгол Улс дахь анхны дотоодын арилжааны банк болов.

2018

- "Маймонсоорс" ХХК-ийн хэрэгжүүлсэн Монголын анхны "LEED Platinum" гэрчилгээтэй ногоон барилгын төслийг санхүүжүүлэв.
- Хөнгөлөлттэй зээл олгох, малчдыг чадавхжуулах замаар бэлчээрийн доройтлыг арилгах, малын эрүүл мэндийг сайжруулах зорилготой Ногоон бэлчээрийн хөтөлбөрийг Мерси Корттой хамтран эхлүүлэв.
- УАНС-ын Үндэсний эрх бүхий байгууллага (NDA) болон Үндэсний зохицуулагч (NFP)-ын чадавхыг бэхжүүлэх зорилгоор УАНС-д өргөн барих Монгол Улсын хөтөлбөрийг боловсруулах, УАНС-тай хамтран ажиллах тогтолцоог бий болгох ажлуудаас бүрдсэн бэлэн байдлыг дэмжих хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэв.
- Ногоон санхүүжилтийн чуулганыг хоёр дахь жилдээ "Эрчим хүчний хэмнэлт" хөтөлбөрийн хүрээнд "Бид дэмжинэ" уриатайгаар зохион байгууллаа.

2019

- Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (MGFC) байгуулахад зориулсан УАНС-ын Төсөл бэлтгэх санхүүжилтийг (PPF) авч амжилттай гүйцэтгэв.
- УАНС-ын хамтын санхүүжилттэй Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг зах зээлд нэвтрүүлсэн ба уг хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад анх удаа эрчим хүчний хэмнэлттэй халаагуур болон амины орон сууцыг сайжруулах дулаалгын зээлийг үндэсний хэмжээнд олгож эхэллээ.
- "Эко дулааны шийдлийг Бид дэмжинэ" уриатайгаар Ногоон санхүүжилтийн чуулганыг 3 дахь жилдээ зохион байгуулж, эко хэрэглээний зээлээр эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, дулаалгын шийдлийг санал болгох сонирхолтой аж ахуйн нэгж, ханган нийлүүлэгчид, иргэд, олон нийтэд нээлттэй байдлаар чуулганыг зохион байгууллаа.

2020

- Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоотой хамтран эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

2021

- УАНС-ын санхүүжилтээр гэр хорооллын бүсэд хэрэгжих "Халаалтын тархмал, бие даасан шийдэл"-ийг бий болгох ТЭЗҮ боловсруулах төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгав.

2022

- НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хот, хөдөөгийн гэр хорооллын иргэдэд зориулж гэрийн дулаалгын цогц шийдлийг санхүүжүүлэх зээлийг олгож эхлэв.
- Монголын орон сууцны зах зээлд ногоон барилгын шийдлийг сурталчлах зорилгоор Монголын Амины Орон Сууцны Инноваци Хөгжлийн Төвтэй хамтран ажиллах санамж бичгийг байгуулав.
- ЕСБХБ, ОУСК, "FMO"-тай 79 сая ам.долларын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ байгуулснаар ногоон санхүүжилтийн хамрах хүрээг хог хаягдлын менежмент болон нөөцийн баялгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр өргөжүүлэх боломжтой болов.
- Эко автомашины зээлийн хөтөлбөрийг дахин сэргээж, ХасЛизингээр дамжуулан 100% цахилгаан автомашиныг санхүүжүүлж, Улаанбаатар хотын агаарын бохирдлын 10% -ыг бүрдүүлж буй тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.
- УАНС-ын санхүүжилтээр Үндэсний эрх бүхий байгууллага (NDA)-ын бэлэн байдлыг дэмжих хөтөлбөрийн дараагийн үе шатыг амжилттай хэрэгжүүлэв. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд оролцогч талуудад зориулсан Бодлогын удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх замаар Үндэсний эрх бүхий байгууллага (NDA)-аас УАНС-тай харилцах харилцаа болон Үндэсний зохицуулагч (NFP)-ын үйл ажиллагааг дэмжих, чадавхийг бий болгох, дотооддоо мөрдөх журам, үйл ажиллагааны гарын авлага, талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зэрэг чадавхи бэхжүүлэх ажлууд хийгдэв.

2023

- Уур амьсгалын компанийн засаглал төслийг эхлүүлэв.
- Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын шилжилтийн төлөвлөгөө болон Тогтвортой засаглалын бүтцийг Төлөөлөн Удирдах зөвлөлөөр батлуулав.
- УАНС-ын санхүүжилттэй Монгол Улсад Эрчим хүчний хэмнэлтийн даатгал (ESI)-ын механизмыг нэвтрүүлэх төслийг "BASE" болон "Тэнгэр Даатгал"-тай хамтран амжилттай хэрэгжүүлж дуусгав.
- 10 кВт/цагийн чадалтай нарны эрчим хүчний системийг ХасБанкны төв албаны байр болон 2 салбарт суурилуулав.

2023 онцлох үйл явдал

Байгаль орчин

»»» 2023 оны Монгол Улсын Онцлох Ногоон банк «««

ХЭРЭГЛЭЭ



76,608,744


шоо метр ус

731,028.7

кВт цаг халаалт

2,380,298.6

кВт.ц цахилгаан



182.3

тонн CO2 Хамрах
хүрээ 1-ын ялгаруулалт

2,750.4

тонн CO2 Хамрах
хүрээ 2-ын ялгаруулалт


2,543,880

тонн CO2 2013 оноос
хойш бууруулсан

Нийгэм

1,172


ИДЭВХТЭЙ АЖИЛТАН
(1,300)
НИЙТ АЖИЛТАН



Эмэгтэй ажилтан



Байгууллагын
Ипотекийн хөтөлбөрт
орсон ажилтнууд



ХАС ТББ-ын
гишүүнчлэл

Үйл ажиллагаа

»»» 23 жилийн үйл ажиллагаа «««

> 1 сая
харилцагч

72
салбар

>7,000
худалдаачид

>50
олон улсын
түншлэл

БОНЗ-ЫН ТОЙМ

Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоо ба бодлого

Эрсдэлийн удирдлага

ХасБанкны эрсдэлийн удирдлага нь өөрийн үйл ажиллагааны эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх өргөн хүрээний нөлөөллийг агуулсан БОНЗ-ын асуудлыг хамардаг бөгөөд бид БОНЗ-ын удирдлагын системийг 2002 оноос хойш хэрэгжүүлснээр БОНЗ-ын зарчмуудыг баримталдагаа батлан харуулж байна. Бид харилцагчийн эрсдэлийн үнэлгээг хийж, мэдээллийн баазыг бүрдүүлж, мөн тогтмол сургалт, семинарууд зохион байгуулснаар зээл болон худалдан авалтын үйл ажиллагаанд оролцож буй ажиллагсдынхаа БОНЗ-ын мэдлэгийг тогтмол баталгаажуулж байна.

Бид 12 сараас дээш хугацаатай, 50 сая төгрөгөөс дээш дүнтэй бизнесийн бүх зээлд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг хийж байна. Салбар нэгжийн зээлийн мэргэжилтэн нь батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу харилцагчийн хөдөлмөр, эрүүл ахуй, байгаль орчны хууль дүрэм журмын гүйцэтгэлийг үнэлдэг бөгөөд уг үнэлгээний аргачлал нь бидэнд харилцагчийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжийг олгодог. Агаарын бохирдол, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт зэрэг байгаль орчин, нийгмийн асуудлуудыг бид шийдвэр гаргалтандаа голчлон анхаарч ажилладаг.

Засаглал

ХасБанк нь Эрсдэлийн засаглалын загвартаа байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлыг бодитойгоор тусгасан бөгөөд Эрсдэл хариуцсан захирлын шууд удирдлаганд ажилладаг Эрсдэлийн бодлого, хяналтын хэлтэс нь тогтвортой хөгжлийн ил тод тайлагнал болон БОНЗ-ын эрсдэлийн удирдлагыг хариуцан ажиллаж байна. Эрсдэлийн засаглалын хамгийн дээд түвшин болох Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын түвшинд шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, зээлийн багцын БОНЗ-ын эрсдэлийн мэдээллээр тогтмол хангадаг.



Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсэг (УАХСАХ)-ийн зөвлөмжийн дагуу Уур амьсгалтай холбоотой тодруулга


Уур амьсгалтай холбоотой эрсдэлийн засаглал <<<

ХасБанк нь уур амьсгалын асуудлыг өөрийн засаглалын тогтолцоондоо нэгтгэх ажлыг байгууллагын шийдвэр гаргах үйл явцаар дамжуулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Эрсдэлийн бодлого, хяналтын хэлтэс нь уг ажлыг хариуцан холбогдох ажилтнуудад уур амьсгалын эрсдэлийг ойлгуулах, Банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар сургалтуудыг зохион байгуулж байна. Түүнчлэн удирдлагын түвшинд буюу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн болон Гүйцэтгэх Удирдлагын гишүүдэд уур амьсгалын өөрчлөлт уур амьсгалын эрсдэлийн талаар сургалт зохион байгуулах замаар мэдлэг түгээх суурь баазыг бий болгохыг зорьж байна.


Бид уур амьсгалын хүчин зүйлсийг нэн тэргүүнд авч үзсэн засаглалын тогтолцоог хэрэгжүүлэх шатандаа явж байна. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2023 онд эрсдэлийн удирдлагын чиг үүрэгт уур амьсгалын эрсдэлийг тусгаж, Банкны стратеги төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой боломжуудыг тодорхойлох албан ёсны Тогтвортой хөгжлийн хороог байгуулахыг зөвшөөрлөө.

2024 оноос эхлэн засаглалын шинэ бүтцэд тусгагдсаны дагуу уур амьсгалын эрсдэлд чиглэсэн тусгайлсан нэгж болон Тогтвортой Хөгжлийн Хороогоор дамжуулан стратегийн зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлтүүдийг оруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Тогтвортой Хөгжлийн Хорооны үйл ажиллагаа нь ХасБанкны үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагатай байдал, тогтвортой үйл ажиллагааг бий болгоход чиглэнэ.


Батлах & хяналт



Удирдах & зохицуулах



Хэрэгжүүлэлт & гүйцэтгэл



Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсэг (УАХСАХ)-ийн зөвлөмжийн дагуу Уур амьсгалтай холбоотой тодруулга

Уур амьсгалтай холбоотой эрсдэлийн засаглал



ТУЗ

- Тогтвортой хөгжлийн стратегийг баталж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь хянах.
- Уур амьсгалын эрсдэл болон нийгэм, байгаль орчин, засаглалын эрсдэлийн удирдлагыг хянах, эрсдэлийн удирдлагын зохих систем болон хяналт зохистой хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулах.
- Эрсдэлийн Удирдлагын Хороо нь уур амьсгалын эрсдэлийн стратеги болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хувьд Банкны ТУЗ-д дэмжлэг үзүүлэх.

Гүйцэтгэх хороо (ЕХСО)

- ХасБанкны Тогтвортой хөгжлийн зорилго, стратеги болон замын зураглалыг тодорхойлох;
- Банкны уур амьсгалын эрсдэлийн удирдлагын хэрэгжилт болон эрсдэлийн үнэлгээг тогтмол хянах.

Тогтвортой хөгжлийн хороо

- Гүйцэтгэх захирал даргална;
- Шилжилтийн төлөвлөгөөний дагуу банк дахь тогтвортой хөгжлийн шийдвэрийн хэрэгжилтийг хянах;
- ХасБанкны нэгжүүдийн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг Шилжилтийн төлөвлөгөөтэй уялдуулах, чиглүүлэх;
- Тогтвортой хөгжлийн стратеги, зорилго, нөөцийн талаар шийдвэр гаргахад зөвлөмж өгөх.

Эрсдэлийн удирдлага

- Нийгэм, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийг багтаасан эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэх;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг хангаж ажиллах;
- Нийгэм, байгаль орчин & уур амьсгалын эрсдэлийн баг нь салбарын болон хориглосон үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээг хийх;
- Зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх болон тайлагнах аргачлалыг боловсруулах, үнэлэх.

Стратеги <<<

ХасБанк нь уур амьсгалын эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэдрэмжтэй байж Монгол Улсын санхүүгийн салбарын ногоон шилжилтийг манлайлахыг зорьж байна. Стратегийн зорилтуудад үйл ажиллагаагаа нүүрстөрөгчийн ялгаруулалтаас ангижруулах, уур амьсгалтай холбоотой эрсдэлийн эсрэг хариу арга хэмжээ авах, эдийн засгийг бүхэлд нь ногоон болгоход хувь нэмэр оруулах зэрэг орно. Зорилгодоо хүрэх замын зураглалыг тодорхойлохын тулд бид ЕСБХБ-тай хамтран Уур амьсгалын эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон Шилжилтийн төлөвлөгөөг боловсруулаад байна.

Уур амьсгалын эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг нь олон улсын болон улс орны шаардлагад нийцүүлэхийн тулд нэн даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хэлнэ. 2024 онд бидний хувьд тэргүүлэх чиглэл бол Монгол Улсын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэрт зорилгоо нийцүүлэн Уур амьсгалын эрсдэлийн стратеги боловсруулах, салбарын бодлогыг тодорхойлох явдал юм.

Уур амьсгалын эрсдэлийн шилжилтийн төлөвлөгөө гэдэг нь Банк болон үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн уур амьсгалын амлалт болон бидний урт хугацааны алсын харааг нэгтгэсэн төлөвлөгөө юм. Засаглал болон эрсдэлийн удирдлагын уялдаа холбоог бий болгосноор үр дүнтэй эрсдэлийн үнэлгээ болон зохицуулагч байгууллагын тайлагналын шаардлагад нийцүүлэх боломжийг бий болгодог. Түүнчлэн, энэхүү төлөвлөгөө нь тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхийн тулд Банкны дотоод нэгжүүдийн оролцоогоор дамжуулан баримтлах уур амьсгалын стратегийг тодорхойлох юм. ХасБанк нь уур амьсгалын зорилгоо ил тод тайлагнаж, стратегидаа тусгаж, санхүүгийн салбарт соёлын өөрчлөлтийг бий болгохыг зорьж байна.

Уур амьсгалын эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Богино хугацаанд авах арга хэмжээ, тухайлбал:

- Холбогдох хууль журам бодлогын судалгаа
- БОНЗ-ын нарийвчилсан сургалт болон хэрэгслүүд
- Хүнрэлт нөхцлийн төсөөлөл ба стресс тест
- Хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол

Уур амьсгалын эрсдэлийн шилжилтийн төлөвлөгөө

Урт хугацааны төлөвлөгөө:

- Уур амьсгалын эрсдэл болон боломжуудыг тодорхойлох
- Стратегийн зорилтуудыг тодорхойлох
- Оролцогч талуудын оролцоог хангах
- Тайлагнах, ил тод байдал

ХасБанкны Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал

Ирээдүйн хэтийн төлөв ба зорилт

ХасБанк нь Монгол Улсыг хүртээмжтэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засагт шилжихэд стратегийн чухал ач холбогдолтой үүрэг гүйцэтгэх амлалт хүлээж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд бид Монгол Улсын тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулах урт хугацааны стратегитэйгээ уялдуулан санхүүгийн хүртээмж, хариуцлагатай санхүүжилт, жендерийн тэгш байдлыг хангахад ихээхэн ач холбогдол өгч байна. Ирэх онд ХасБанк нь эрчим хүчний хэмнэлтийн шийдэл, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, тогтвортой эдийн засгийн хөтөлбөр, ЖДҮ-ийн чадавхийг бэхжүүлэх санаачилгуудыг үргэлжлүүлэн дэмжин ажиллах болно.

Эрсдэлийн удирдлага <<<

Уур амьсгалын эрсдэлтэй холбоотой материаллаг байдлын үнэлгээ

Олон улсын хэмжээнд, санхүүгийн байгууллагууд уур амьсгалын эрсдэлийг зайлшгүй анхаарах шаардлагатай болж байна. Уур амьсгалын эрс тэс үзэгдлийн шууд аюулаас эхлээд хууль тогтоомж зохицуулалтийн өөрчлөлтийн шууд бус үр дагавар нь уур амьсгалын эрсдэлийн стратегийн хариу арга хэмжээг идэвхитэй авахыг шаардаж байна. Материаллаг байдал гэдэг нь хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллага болон харилцагч гэх мэт оролцогч талуудын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж болохуйц асуудал, эрсдэл болон боломжийг тодорхойлох үйл явц юм.

ЕСБХБ-тай хамтран, бид эрсдэлийн удирдлагын стратеги болон санхүүгийн шийдвэрүүд нь уур амьсгалын эрсдэлд тэсвэртэй эсэхийг баталгаажуулахын тулд материаллаг байдлын үнэлгээг хийх шатандаа явж байна. Бид уг үнэлгээг Дэлхийн ил тод тайлагналын (GRI) стандартын дагуу хийж, уур амьсгалтай холбоотой томоохон асуудлын эрсдэл, боломжийг тодорхойлох ба уг үйл явц нь Монгол Улсын биет болон шилжилтийн эрсдэлд өртөмтгий байдал болон зохицуулалтын суурь дүн шинжилгээ хийх боломжийг олгох юм. Бид зээлийн багцын эрсдэл өндөртэй секторыг тодорхойлсноор ирээдүйн нөхцөл байдлыг урьдчилан таамаглаж, стратегиа түүнд нийцүүлэн өөрчлөхийг зорих болно.

Сектор	Биет эрсдэл	Нийлүүлэлтийн сүлжээний тасалдал	Өртөг нэмэгдэх	Хөрөнгийн үнэ цэнээ алдах	Эрэлтийн өөрчлөлт	Нэр хүндийн эрсдэл	Зохицуулагч байгууллагын эрсдэл
Бөөний болон жижиглэнгийн худалдаа		●					
Үл хөдлөх хөрөнгө, Түрээс, Бизнесийн үйл ажиллагаа			●	●	●	●	
Үйлдвэрлэл		●	●			●	●
Барилга			●	●	●	●	
Тээвэр ба агуулах	●		●				●
Уул уурхай, олборлолт	●				●	●	
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, ан агнуур	●						
Цахилгаан, газ, уур, агааржуулагч	●						●

Уур амьсгалын эрсдэлийн удирдлага



Уур амьсгалын эрсдэлийн засаглалд Банкны шийдвэр гаргах дээд түвшний удирдлагын хороо, Тогтвортой хөгжлийн хороо болон бусад нэгжүүд хамаардаг бөгөөд эдгээр нь эрсдэлийн удирдлагад хяналт тавьж, уур амьсгалын эрсдэл ба боломжуудыг тодорхойлоход хамтран ажилладаг.

Бид уур амьсгалын нөлөөнд өртөмтгий салбаруудыг багцын бүтэц, зорилгоор нь тодорхойлж, стратеги төлөвлөлтөөр дамжуулан БОНЗ-ын эрсдэлд өртөмтгий байдлыг тооцно. Бид эрсдэлийн удирдлагын сайн тогтолцоо бэхжүүлэхийн тулд уур амьсгалын эрсдэлийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тогтолцоонд нэгтгэхээр ажиллаж байна.

ХасБанк нь ил тод тайлагнахаас гадна материаллаг байдлын үнэлгээ хийж, уур амьсгалын эрсдэлийг БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээтэй нэгтгэж мөн уур амьсгалын эрсдэлтэй холбоотой хүндрэлт нөхцөлийн төсөөлөл болон багцын дүн шинжилгээ хийх болно.

ХасБанк нь нэгдсэн механизмаар дамжуулан уур амьсгалтай холбоотой эрсдэлийг шийдвэрлэх, идэвхтэй удирдах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Бид эдийн засгийн салбар бүрт уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй сөрөг нөлөөллийг системтэйгээр хянаж, эрсдэлд өртөх эмзэг байдлыг багасгах стратегийг хэрэгжүүлж, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлнэ.

ХасБанк нь эрсдэлийн удирдлагын загварт БОНЗ-ын асуудлыг бодитойгоор тусган, ил тод, хариуцлагатай байх амлалтынхаа дагуу уур амьсгалын стратегид үйл ажиллагааныхаа талаар тодорхой тусгаж, гадаад орчны зохицуулалт, СТОУС-ын удирдамж, олон улсын стандартыг мөрдөнө.


Уур амьсгалын эрсдэлийн хэм хэмжүүр ба зорилт <<<

Цаашид ХасБанк нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулах жишиг үзүүлэлт, санхүүжүүлсэн ялгаруулалтаа ил тод тайлагнах, уур амьсгалын эрсдэлийг хэмжих зэрэг уур амьсгалын стратегийн тодорхой зорилтуудаа тодорхойлох юм. Бид цаашдаа салбарын онцлогт тохирсон зорилтуудыг тодорхойлох, ногоон санхүүжилтийг дэмжих, үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэртэй уялдуулан хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, материаллаг эрсдэлийг стратегидаа тусгах ажлуудыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Эдгээр хэмжигдэхүйц зорилтууд нь ХасБанкны ил тод байдал, хариуцлагатай байдал, Монголын банкны салбарт тогтвортой үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахаар зорьж буй үүрэг амлалт, хүчин чармайлтыг илтгэж байна.

Уур амьсгалын эрсдэлийн хувьд, ХасБанк нь тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, уур амьсгалын засаглалын шинэ тогтолцоог хэрэгжүүлэх, урт хугацааны стратегиа тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах бодит үйл ажиллагаагаа тодорхойлсон. Эдгээр стратегийн үр нөлөөг 2024 оны гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) болон зорилтын хэрэгжилтээр хянан хэмжинэ. Эдгээр үзүүлэлтийн дагуу ахиц үр дүнг үнэлэхдээ бид үйл ажиллагааны бодлого, журам болон оролцогч талуудын оролцоог тасралтгүй сайжруулах болно.

Уур амьсгалын эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний II үе шатыг эхлүүлэх

Уур амьсгалын эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шилжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх



Монгол Улсын ҮХТХН болон Парисын хэлэлцээрт нийцэх



Байгаль орчны гүйцэтгэл



Хамрах хүрээ 1 ба 2-ын ялгаруулалт

ХасБанк нь үйл ажиллагааныхаа нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянахын тулд мэдээ мэдээллийг идэвхтэй цуглуулж дата бааз бий болгож байна. Бид эрчим хүч, түлш, усны хэмнэлттэй хэрэглээг дэмжих, цаасны хэрэглээг багасгах, мөн хог хаягдлаа зөв зохицуулах зэрэг байгаль орчныг хамгаалах арга хэмжээг дотооддоо авч хэрэгжүүлж байна.

Тээврийн хэрэгсэл



182.31
тонн CO2

Хамрах хүрээ 1

Халаалт



646.23
тонн CO2

Хамрах хүрээ 2

Цахилгаан



2104.18
тонн CO2

Эрчим хүчний хэрэглээ

731,028.79 кВт.ц




Нийт халаалтын
хэрэглээ

2,380,298.61 кВт.ц



Нийт цахилгаан
хэрэглээ



Эрчим хүчний хэмнэлттэй засварын ажил

2023 онд бидний эрчим хүч, дулааныг хэмнэх дараах төслүүдийг хэрэгжүүллээ: 2021-2023 оны хооронд төв алба болон салбаруудад их засвар хийж цахилгааны сүлжээг шинээр сольсноор эрчим хүчний хэмнэлттэй болсон.


Нарны фото цахилгаан систем

207,301.80 кВт.ц
Төлөвлөсөн жилийн үйлдвэрлэлт


Жилд 180.6 тонн
CO2 ялгаруулалтын бууруулалт

19.6kW
Төв байрны
нарны хавтан


15%
Эрчим хүчний
хэмнэлт



Сэлэнгэ, Багануур салбарын нарны эрчим хүчний систем



Сэлэнгэ, Багануур салбарын эрчим хүчний хэмнэлт




Цогцэций салбарын дулааны зардлын хэмнэлт

Салбарын эрчим хүчний хэрэглээг 40% бууруулах зорилгоор Сэлэнгэ, Багануур салбаруудын барилгад 9.8 кВт-ын нарны цахилгаан эх үүсгүүрийн систем суурилуулах ажил гэрээ байгуулах шатандаа явж байна.

Цогцэций салбарыг төвийн дулааны сүлжээнд холбосноор дулааны зардлыг 60%-аар буурууллаа.

Төв байрны дулааны системийн халаалтын усыг дахин хэрэглэх, эргэлтийн насос суурилуулснаар барилгын дулааны зардлыг 30%-аар бууруулсан.

Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах санаачилгууд



Бензин хөдөлгүүртэй машинруу шилжих

Дизель хөдөлгүүртэй автомашины тоог цөөрүүлэхийн тулд зөвхөн бензин хөдөлгүүртэй автомашиныг ашиглах бодлогыг баталж нэвтрүүлээ.




Төв оффис дахь цахилгаан машин



Төв оффист ажлын өдөр ашиглах 5 цахилгаан машин худалдан авсан.

Автомашиныудын шатахууны зардлыг бууруулаад зогсохгүй ажлын өдрүүдэд автомашиныг улсын дугаарын хязгаарлалтад өртөхгүйгээр 100% ашиглах боломжийг бий болгосон.



Дата төвд түлшний зардлын хяналт

Шатахууны хяналтыг сайжруулснаар жилд 120 сая төгрөг хэмнэсэн.

Дата төв болон төв байранд нэмэлт цахилгаан үүсгүүрийн түлшний зардлын хяналтыг сайжруулснаар өвөл, зуны түлшний хооронд шилжих зардлыг 120 орчим сая төгрөгөөр буурууллаа.





Усны хэрэглээ



Санаачлага А: Усны хэмнэлттэй системүүд



Төв оффис болон засвар хийсэн бүх салбар нэгжүүдэд усны хэмнэлттэй угаалтуур болон бусад тоног төхөөрөмжийг суурилуулсан.



Санаачилга Б: Төв албаны байранд ус халаагч бойлер суурилуулалт



Төв оффисын байранд ус халаагч суурилуулснаар төв барилга нь байнгын халуун устай байх боломжтой болсон. Ингэснээр төвийн шугамын халуун усыг ашиглах шаардлагагүй болж, халуун усны шугамыг хаасан.

76,608,744 шоо метр



Нийт усны хэрэглээ






Хог хаягдлын менежмент

Стратегийн бодлогын хүрээнд бид хог хаягдлын ихэнх хэсгийг уламжлалт хог устгах аргаас өөрөөр дахин ашиглахад хувь нэмрээ оруулдаг боллоо. Жишээлбэл, хугацаа нь дууссан архивын баримтуудыг устгаж, дахин боловсруулахаар өндөгний хайрцгийн үйлдвэрт тушааж байна. Бид байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах амлалтаа үргэлжлүүлэхийн тулд хог хаягдлын тогтвортой менежментийн бусад олон арга туршлагыг хэрэгжүүлсээр байна.


Хог хаягдал



Дахин хэрэглээ



Цаасны дахин боловсруулалт



Архивын цаасыг өндөгний хайрцаг болгож дахин боловсруулсан



Тогтвортой санхүү

Тогтвортой санхүүгийн санаачилгууд

ХасБанк нь ногоон зээлийн хөтөлбөрүүд болон төсөл хэрэгжүүлэх замаар Монгол Улсад тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх ажлуудыг дэс дараатайгаар авч хэрэгжүүлж байна. Бид бичил, жижиг, дунд бизнесийг дэмжиж, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх, эмзэг бүлгийн иргэдийг дэмжих санхүүгийн өвөрмөц бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна. ХасБанкны ногоон санхүүжилт нь Монгол Улсын Ногоон Таксономи болон олон улсын жишигт нийцсэн болно. Бид тогтвортой хөгжлийн үзэл санааг зээл, хөрөнгө оруулалт гэх мэт бизнесийн үндсэн чиг үүргүүдэд тусгаж, нийгмийн өргөн хүрээний зорилгыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулж, Монголын санхүүгийн салбарт ногоон санхүүжилтээр манлайлагч байр сууриа бататгасаар байна.

Эко банкны газар

Эко банкны газар нь 2009 онд анх байгуулагдсан ба тогтвортой санхүүжилтийн шийдлээр мэргэшсэн. Байгаль орчинд ээлтэй банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлтийг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, уур амьсгалтай холбоотой асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Тус газар нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын нүүрстөрөгч багатай эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгальд ээлтэй төрөл бүрийн хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, өргөжүүлж, хэрэгжүүлсээр ирсэн билээ. Эко банкны газар нь олон улсын түншүүд, төрийн байгууллагууд, дотоодын төрийн бус байгууллагууд, харилцагчид зэрэг олон төрлийн оролцогч талуудтай хамтран ажиллаж байна.

ХасБанк нь Уур амьсгалын ногоон сан (УАНС)-тай нягт хамтран ажилладаг ба УАНС-тай магадлан итгэмжлэлийн мастер гэрээ байгуулсан дэлхий дахины анхны арилжааны банкны хувьд бид Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад бодит хувь нэмрээ оруулах нь бидний үүрэг хариуцлага гэж үздэг билээ.

Бид магадлан итгэмжлэгдсэн эхний 5 жилийн хугацаанд УАНС-тай хамтран 9 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд үүний 6 төсөл нь хэрэгжиж дууссан, 3 нь одоогоор үргэлжилж байна. ХасБанк 2022 онд дахин магадлан итгэмжлэгдсэний дараа 2023 оны 10 дугаар сард эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт зориулж 8 сая ам.долларын нэмэлт санхүүжилтыг УАНС-гаас хүлээн авсан. УАНС болон бусад хамтрагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр ХасБанк нь Монгол Улсын аж ахуйн нэгж, айл өрхүүдэд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний технологийг санхүүжүүлэх зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож байна.

2013 оноос хойш бид хүлэмжийн хийн ялгарлыг

2,543,880

тонн CO₂-аар бууруулсан.

Үүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь

183,274,544

навчит болон шилмүүст модны 10 жилд
ургасантай тэнцэж байна.

1.3x

Нэг га-д 300 мод гэж тооцвол
Улаанбаатараас 1.3 дахин том.

Төсөл хөтөлбөрүүд

ХасБанкны тогтвортой санхүүгийн үйл ажиллагаа нь чадавхийг бэхжүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх, ногоон зээл олгох, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавихад чиглэдэг.

Хүлэмжийн хийг бууруулах ЖДБ-ийн зээлийн хөтөлбөр

Төслийн зорилго: ЖДБ-ийг эрчим хүчний хэмнэлтэд хөрөнгө оруулалт хийж, нүүрстөрөгч бага ялгаруулдаг бизнесийн загваруудыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Батлагдсан он

2016

Төслийн нийт үнэ цэнэ

**60 сая
ам.доллар**

Төслийн CO2 бууралтын
зорилтот хэмжээ

1.2 сая тонн

Монгол Улсын бизнес эрхлэгчдийн 90 гаруй хувь нь бичил, ЖДБ-ийн ангилалд багтдаг бөгөөд ихэнх нь эрчим хүчний хэмнэлтгүй тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаа явуулж байна. 2016 онд УАНС-гаар батлуулсан Хүлэмжийн хийг бууруулах ЖДБ зээлийн хөтөлбөр нь ХасБанкны тус сантай хамтран хэрэгжүүлсэн анхны хөтөлбөр бөгөөд уг хөтөлбөр нь Монгол Улсын ЖДБ-ийн зах зээлд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Мөн уг хөтөлбөрийн хүрээнд эмэгтэй ЖДБ эрхлэгчдийг илүү хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр дэмжин ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны харилцагчдыг чадавхжуулах сургалт, зээлийн мэргэжилтнүүдэд зориулсан эко зээлийн талаарх сургалт, зээлийн шалгуур үзүүлэлтийг хангах технологийн жагсаалтыг гаргах, мөн ЖДБ эрхлэгчдэд зориулсан ногоон зээлийн форум зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.



Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөр

**Төслийн
зорилго:**

Эрчим хүчний хэрэглээг 20-оос доошгүй хувиар бууруулах халаалтын шийдэл, дулаалга болон амины орон сууцны зээл олгох.

Батлагдсан он

2018


Төслийн нийт үнэ цэнэ

**21.5 сая
ам.доллар**

Төслийн CO2 бууралтын
зорилтот хэмжээ

0.47 сая тонн

ХасБанк 2019 онд Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг (EECLP) хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг хөтөлбөр нь Монгол Улсын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн ашиглах хэрэглээнд шилжүүлэх, нүүрс болон эрчим хүчний хэмнэлтгүй зуухны хэрэглээг бууруулахад чиглэсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд халаалтын цахилгаан хэрэгсэл, гэр байшингийн дулаалга болон эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл зэргийг санал болгодог. 2022 онд ХасБанк нь эрчим хүчний аудиторудтай хамтран сургалт зохион байгуулж эхэлсэн ба НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран маркетингийн аян өрнүүлж, бодит байдлын судалгаа хийх зэргээр хөтөлбөрийн хэрэгжих хүрээг тэлэхэд чиглэсэн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авч ажиллахад түлхүү анхааран ажиллалаа. Мөн ХасБанк нь Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж, Монголын амины орон сууцны инноваци хөгжлийн төвтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор Хамтран ажиллах санамж бичиг байгуулж ажиллалаа. ХасБанк нь дөрөв дахь жилдээ УАНС, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран эрчим хүчний хэмнэлттэй халаалтын шийдлүүд, дулаалгыг санхүүжүүлэхэд зориулж хүүгийн хөнгөлөлттэй хэрэглээний зээл олгож байна. Түүнчлэн бид Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр (EECLP)-ийн хүрээнд олгосон эко хэрэглээний зээлийнхээ үр дүнд хүлэмжийн хийн ялгарлыг нийтдээ 5,557 тонноор буурууллаа.



Монголын Ногоон Санхүүгийн Корпораци

Төслийн зорилго:

Хамтран ажиллах дотоодын санхүүгийн байгууллагуудаар дамжуулан бизнесүүдэд эрчим хүчний хэмнэлтийг санхүүжүүлэх зээл, иргэдэд дулаалга болон ногоон амины орон сууцны моргейжийн зээл олгох.

Батлагдсан он
2020

Төслийн нийт үнэ цэнэ
49.7 сая ам.доллар

Төслийн CO2 бууралтын зорилтот хэмжээ
3.8 сая ТОНН

ХасБанкнаас УАНС-д хүргүүлсэн Санхүүжилтийн санал болох FP153: Монголын ногоон санхүүжилтийн корпораци (MGFC) байгуулах төсөл нь УАНС-гийн Удирдах зөвлөлөөр дэмжигдэж батлагдсан бидний дөрөв дэх төсөл юм. Монголын ногоон санхүүжилтийн корпораци нь Монголын анхны ногоон санхүүгийн байгууллага бөгөөд Монгол Улсын 2050 он хүртэлх хөгжлийн үзэл баримтлалд заасан “Байгаль орчинд ээлтэй ногоон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх” зорилгыг хэрэгжүүлэх гол арга зам болно. Уг төслийг УАНС, Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх бөгөөд гурван талт хамтын ажиллагаа нь Монгол улсын ногоон санхүүгийн хөгжил, чадавхыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэх юм.



Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм (ЭХХД)

Төслийн зорилго: Эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэхэд учирч буй эрсдэлийг бууруулж, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих

ХасБанк нь BASE болон Тэнгэр Даатгалтай хамтран ЖДБ-үүдийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг хэрэгжүүлэхэд түлхэц өгөх өвөрмөц даатгалын загвар болох Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын (ЭХХД) механизмыг Монгол Улсад нэвтрүүлээ. 2023 оны 2 дугаар сард стратегийн түншлэл бүхий энэхүү механизмыг анхлан олон нийтэд танилцуулсан ба уг механизм нь Монгол улсад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдэх боломжтой, Монголын өвөрмөц хэрэгцээнд нийцсэнээрээ онцлог юм. Энэхүү механизмыг бий болгохын тулд ХасБанкнаас өмнө нь хийлгэж байсан Техник эдийн засгийн үндэслэлээр Монголын ЖДБ-үүд, ялангуяа нүүрстөрөгчийн ялгаруулалт ихтэй эдийн засгийн салбаруудад Эрчим хүчний хэмнэлтийн даатгалыг нэвтрүүлэх асар их боломж байгааг тогтоосон байдаг. Уг механизмыг нэвтрүүлсний дараа ХасБанк 2023 оны 11 дүгээр сард Эрчим хүчний хэмнэлтийн даатгалыг хэрэглэсэн хоёр туршилтын төслийг хэрэгжүүлсэн нь ихээхэн үр дүнд хүрсэн билээ. Банк цаашдаа Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын чиглэлээр Тэнгэр даатгалтай хамтран ажиллахын зэрэгцээ даатгалын энэхүү шинэ бүтээгдэхүүнийг урт хугацаанд амжилттай болгохын тулд дотоодын технологи нийлүүлэгчидтэй нягт хамтран ажиллахыг зорьж байна. Мөн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг байгууллагуудтай уулзаж, Эрчим хүчний хэмнэлтийн даатгалыг төсвийн санхүүжилтээр хийгдэх төслүүд, худалдан авалтад ашигласнаар тогтвортой байдал, эрчим хүчний хэмнэлтийг олон нийтэд сурталчлан таниулахад чухал ач холбогдолтой болох талаар онцлон ярилцав.



Онцлох үйл явдлууд

Тогтвортой санхүүгийн долоо хоног 2023

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Тогтвортой санхүүгийн долоо хоног 2023” чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулсан “Эрчим хүчний хэмнэлттэй барилгын санхүүжилт” салбар хуралдаан нь 2023 оны онцлох арга хэмжээний нэг болов.

Энэхүү салбар хуралдааны гол зорилго нь барилгын салбарт эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шаардлагатай бодлого, технологийн шинэчлэл, санхүүгийн стратегийн талаар өндөр түвшний хэлэлцүүлэг өрнүүлэх болон эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны экосистемийг хөгжүүлэх байв. Энэ удаагийн хуралдаанд оролцогчид эдгээр чухал асуудлын талаар харилцан ойлголцож, нэгдсэн байр суурьтай боллоо.

Хуралдаанаар хэд хэдэн чухал асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

- Эрчим хүчний хэмнэлттэй барилга, орон сууцны бүтээн байгуулалтыг дэмжих төрийн бодлого.
- Эрчим хүчний хэмнэлттэй барилгын хамгийн сүүлийн үеийн технологийн шийдлүүдийг судлах, холбогдох боломж, сорилтуудыг судлах.
- ХасБанкнаас эрчим хүчний хэмнэлттэй бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх арга барил, түүний үр дүнг хянах, хэмжих аргачлалын талаарх ойлголтын цуврал илтгэл, гүнзгийрүүлсэн хэлэлцүүлгээр авч хэлэлцсэн.

Ногоон зээлийн өдөрлөг

ХасБанк 2023 оны 9 дүгээр сард байгаль орчны талаарх мэдлэг, тогтвортой санхүүжилтийг дэмжих шинэлэг арга хэмжээ болох Ногоон зээлийн өдөрлөг зохион байгууллаа. Уг өдөрлөгийн үеэр эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, дулаалгын шийдэл зэрэг байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, жилийн 2-3 хувийн хүүтэй, эко хэрэглээний зээлийг иргэдэд санал болгов. Ногоон зээлийн өдөрлөг нь 28 ханган нийлүүлэгч байгууллагын идэвхтэй оролцоотойгоор иргэдэд байгаль орчинд ээлтэй сонголт хийх боломжийг олгохын зэрэгцээ тогтвортой хөгжлийг эрхэмлэдэг бизнесүүдийг дэмжих зорилготой юм. Хамтын хүчин чармайлт нь байгаль орчныг хамгаалах олон нийтийн хандлагыг дэмжсэн эрч хүчтэй платформыг бий болгосон ба энэхүү арга хэмжээ нь ногоон зээлийн шийдлүүдийн хүртээмжийг сайжруулах, тогтвортой хөгжлийг санхүүгийн хувьд давуу талтай болгох талаар бидний гаргаж буй хичээл зүтгэлийн илэрхийлэл юм.



Иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины орон сууцны зээлийг танилцуулах автобустай аялал

2023 оны 7 дугаар сард ХасБанк нь мэдээлэл өгөх автобустай аялал зохион байгуулж, оролцогчдод хамтран ажилладаг 7 компанийн загвар байшингуудыг өөрийн биеэр үзэхийг санал болгов. Түүнчлэн аяллын үеэр бусад 10 хамтрагч байгууллагуудын эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны сонголтуудыг цахим хэлбэрээр танилцууллаа. Энэхүү арга хэмжээнд 120 оролцогч хамрагдаж, хамгийн сүүлийн үеийн эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны шийдлүүдийн талаар иж бүрэн ойлголт өглөө.



“Ногоон зээлийн өдөрлөг” болон “Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины орон сууцны зээлийг танилцуулах автобустай аялал” зэрэг арга хэмжээний хүрээнд 2023 оны 9 дүгээр сард эрчим хүчний хэмнэлттэй зээлийн борлуулалт өсч, эдгээр зээлийн тоо өмнөх сарын үзүүлэлтээс 2 дахин буюу 102.29%-аар өссөн нь байгальд ээлтэй санхүүжилтийг нэмэгдүүлэхэд харилцагчдад чиглэсэн “мэдлэг түгээх” төрлийн арга хэмжээ илүү амжилттай байдгийг харуулж байна.



“She owns (тэр өмчтэй)” арга хэмжээ

ХасБанк нь Монголын эмэгтэйчүүдийн скаутын холбооноос зохион байгуулсан Улаанбаатар хотын 15-25 насны залуу охидыг чадавхжуулах зорилготой "SheOwns" арга хэмжээг санхүүжүүлэн дэмжиж ажиллалаа. Энэхүү арга хэмжээ нь санхүү, бизнес эрхлэлтийн талаар мэдлэг олгох, урам зориг өгөх, амжилтын түүхүүдийг хуваалцах, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэв.

Нийт 70 гаруй оролцогчид “Тэгээс эхэлсэн амжилтын түүх”, “Үе тэнгийн охины түүх”, “Бизнес эхлүүлэх боломжууд” зэрэг олон сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлээ. Мөн энэхүү арга хэмжээний үеэр бизнесийн санаа, маркетинг, кейс судалгаа, санхүүгийн менежмент, багаар ажиллах зэрэг сэдвээр интерактив хичээлүүдийг зохион байгууллаа. Нэмж дурдахад БСШУЯ-ны 7 багш оролцож, залуу эмэгтэйчүүдэд урам зориг өгөх зорилготой дадлага сургалтад хувь нэмрээ орууллаа.



Үр Нөлөөний Хэмжилт




ХасБанк нь нийт 87.4 сая ам. долларын санхүүжилтийг ногоон зээлийн зориулалатаар татан төвлөрүүлснээс 32.4 сая ам. долларыг нь Уур амьсгалын ногоон сангаас (УАНС) олгосон байна. Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэн бидний тогтвортой хөгжлийн санхүүжилтийн санаачилгын үр дүнд буюу 2013 оноос хойш бид хүлэмжийн хийн ялгарлыг 2,543,880 тонн CO₂-аар бууруулсан байна. Үүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь 182,274,544 ширхэг навчит болон шилмүүст модыг 10 жил ургуулсантай тэнцэж байна.

Түүнчлэн ХасБанк нь Монгол Улсын тогтвортой хөгжилд өөрийн чухал хувь нэмрээ оруулсаар ирсэн бөгөөд Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ToC), Монгол Банк, Санхүүгийн Зохицуулах Хорооноос ХасБанкны үйл ажиллагааг өндрөөр үнэлсээр ирсэн билээ. Эдгээр шагнал өргөмжлөлүүд нь ХасБанкыг тогтвортой хөгжлийн зарчмуудыг үндсэн үйл ажиллагаандаа бодитой нэвтрүүлсэн, түүнчлэн байгаль орчин, нийгэмд эерэг нөлөөллийг бий болгож манлайлан ажиллаж буйн баталгаа юм.




НИЙГЭМ


Ажилтан ба хүйсийн харьцаа




Эмэгтэй ажилчдын




Нийт эмэгтэй мэргэжилтэн




Төв болон оффисын хэлтсийн эмэгтэй захирлууд



Салбар нэгжийн эмэгтэй захирлын тоо



Гүйцэтгэх удирдлагын эмэгтэй гишүүдийн тоо



ТУЗ-ийн эмэгтэй гишүүдийн тоо

Ажилтны тэтгэмж/хангамж

ХасБанк нь ажилтнуудынхаа нийгмийн хамгаалал, сайн сайхан байдлыг чухалчилдаг бөгөөд ажилтнуудын хангамжийг цогцоор нь олгож, тогтвортой ажиллах орчныг бүрдүүлдэг. Ажилтнуудын сэтгэл ханамж, урам зоригийг нэмэгдүүлэхийн тулд Банк нь холбогдох хууль тогтоомжийн дагуу урамшуулал, нөхөн олговор, тусламж олгон эрүүл мэнд, санхүүг нь дэмжих хөтөлбөрт хамруулж, түүнчлэн олон жил ажилласан ажилтнуудын тэтгэврийн тогтолцоо нь ажилтныг тогтвортой ажиллуулахад чухал хувь нэмэр оруулдаг. Түүнчлэн бид орон сууцны хөнгөлөлттэй зээл, уян хатан ажлын цаг, ажилтнуудын төрөл бүрийн хэрэгцээг хангахад зориулан нэмэлт цалинтай амралт олгодог. Тухайлбал, Банкны ажилтанд жилд 3 өдрийн цалинтай чөлөө олгодог бөгөөд үүний 1 нь төрсөн өдрийн цалинтай чөлөө бол 2 нь Гүйцэтгэх захирлын зүгээс ажилтанд олгодог цалинтай 2 өдрийн амралт юм.



>1000

ажилтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан



158

ажилтан амаржсаны тэтгэмж авсан

Эрүүл мэндийн даатгал

ХасБанк нь ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, тэдний стрессийг бууруулах арга хэмжээ авах, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг дагаж мөрдөх замаар ажилтнуудынхаа эрүүл мэндийг нэн тэргүүнд тавьдаг. Энэ жил бид 1000 гаруй ажилтнуудаа үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэгт хамруулаад байна.



20

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан

Ажилтны орон сууцны зээлийн хөтөлбөр

ХасБанк нь ажилтнуудынхаа мөрөөдлийн байраа авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2003 оноос хойш Ажилтны орон сууцны зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт ХасБанканд 12 сараас дээш хугацаагаар ажилласан бүх ажилтнууд хамрагдах боломжтой бөгөөд 240 хүртэл сарын хугацаа, эргэн төлөлт, урьдчилгаа төлбөрийн уян хатан нөхцөлтэй байдгаараа онцлог юм. 2023 онд бид уг хөтөлбөрийг шинэчилж урьдчилгаа төлбөрийг 15 хувиас 10 хувь болгон бууруулсан.



361

ХВ-ийн байрны зээлийн хөтөлбөрт орсон ажилтнууд

Тэтгэврийн данс

ХасБанк нь анх 2007 онд Тэтгэврийн дансны хуримтлалын хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 2018 онд тусгай нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүн рүү шилжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг тэтгэврийн бодлого, хүн ам зүйн чиг хандлагад нийцүүлэн ажилтнуудаа тогтвортой хадгаламж, өндөр хүүний өгөөж хүртэж, тэтгэвэрт хуримтлалгүй гарах эрсдэлээс хамгаалж байна. Ажилтан нь ХасБанктай хөдөлмөрийн гэрээ байгуулсан цагаас уг тэтгэврийн данс нээгдэх бөгөөд хадгаламжийн хувь хэмжээг тухайн ажилтны жилийн үнэлгээгээр тогтоодог.



120

Байрны зээлийн хөтөлбөрт шинээр орсон ажилчид



1157

ХВ-ийн тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтнууд

1 жил

2 жил

3 жил

4 жил

5 жил

20%

40%


60%

80%

100%

Ажилтны сургалт, хөгжил

ХасБанк нь бизнесийн загвар, байгаль орчин, нийгмийн асуудал болон бусад хэрэгцээ шаардлагадаа тохирсон сургалтын хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулж, ажилтнуудаа тасралтгүй суралцах боломжоор хангахыг эрхэмлэдэг. Банкны үйл ажиллагаанд нэн шаардлагатай ажилтны ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэх, авьяас чадварын тогтвортой байдлыг хангах арга хэмжээг байнга хэрэгжүүлж байна.



171 Шинэ ажилтнуудад зориулсан сургалт

175 ХасБанкны talent.lms платформоор дамжуулан ажлын байран дахь жендэр ба бэлгийн дарамтын сургалт

68 Гүйцэтгэх удирдлагын баг болон төв албаны холбогдох ажилтнуудад зориулсан Тогтвортой байдал ба уур амьсгалын эрсдэлийн менежментийн сургалт



328

Салбар, мэргэжилтнүүд болон бусад ажилтнуудад зориулсан Эко банкны бүтээгдэхүүний сургалт

1,246

Хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл түгээх арга хэмжээ, семинар

Нийгмийн оролцоо ба хөрөнгө оруулалт

Тэртээ 20 жилийн өмнө ХасБанкны хүсэл, зориг нийлсэн залуучуудын санаачлагаар байгаль эх дэлхий болон ирээдүй хойч болсон хүүхэд багачууддаа туслах, нийгэмд өөрсдийн хувь нэмрээ оруулах зорилгоор “Хөгжилийн Алтан Сан” холбоо ТББ үүсгэн байгуулсан. ТББ нь хүүхдийн хөгжил, хүүхдийн боловсрол, байгаль орчин гэсэн үндсэн 3 чиглэлийн хүрээнд, Хасбанкны үе үеийн ажиллагсдын сайн дурын оролцоо, дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

ТББ нь анх байгуулагдсан цагаасаа эхлэн Хүүхдийн хөгжлийн чиглэлээр “Авьяастан” хөтөлбөрийг санаачлан амьдралын нөхцөл, боломж тааруу боловч урлаг, спортын гоц авьяастай хүүхдүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж өнөөдрийг хүртэл 100 мянга гаруй хүүхдийг ивээн тэтгэсэн түүхтэй.

Нийгмийн болон санхүүгийн боловсрол олгох зорилготой Афлатон, Тэмүүлэл хөтөлбөр нь анх 2009 оноос эхлэн Монгол улс даяар амжилттай хэрэгжиж 21 аймагт, 117 сургуулийн 600 гаруй багш, 360 гаруй мянган хүүхдэд санхүүгийн боловсролыг түгээснээр энэхүү хөтөлбөрийн агуулга нь Боловсролын салбарт өөрчлөлт оруулж, Ерөнхий боловсролын ахлах ангид сонгон үзэх “Бизнес судлал” хичээлийн суурь болсон юм. Төслийн үр дүнд хүүхдүүд:

- Мөнгө болон бусад баялгийн үнэ цэнийг ойлгож мэдрэх, хуримтлуулах,
- Мөнгийг ухаалгаар зарцуулах,
- Мөн өөртөө итгэлтэй, үүргээ ухамсарлаж, эрхээ эдэлсэн нийгмийн хариуцлагатай иргэн болон төлөвших мэдлэг, чадварыг эзэмшдэг.

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, цөлжилтийг бууруулах чиглэлээр “Хас төгөл”-ийг санаачлан Хас банктай хамтран УБ хот, 21 аймагт нийт 29 төгөл, 40 мянган мод тарьж ургалтын хувь 87%-тай ургаснаар байгаль орчин экологийн тэнцвэртэй байдлыг хадгалахад хувь нэмрээ оруулсаар байна.

— С.Анхцэцэг

*Хөгжилийн алтан сан холбоо ТББ – ын Гүйцэтгэх захирал
Хасбанкны Касс, Карт, АТМ-ын үйл ажиллагааны хэлтсийн захирал*



815

сая
төгрөгийн
сан

100,000

оролцогчид
(2003-2014)

>1,000

гишүүд

110

ХасБанкны
хөрөнгө
оруулалт
(2009-2023)

80%

ХасБанкны
ажилтнууд

Төсөл, хөтөлбөрүүд

Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ нь анх ХасБанкны ажилтнуудын сайн дурын хүчин зүтгэлээр 2003 оны 8 дугаар сард үүсгэн байгуулагдаж байсан. Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-ын эрхэм зорилго нь Монголын хойч үеийг өсгөн хүмүүжүүлэх, тэдний амьдрах орчныг сайжруулах юм. Гишүүнчлэлийн татвар, хандив, буцалтгүй тусламж, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны орлогыг хослуулан санхүүждэг ба Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ нь 1000 орчим гишүүнтэй болон өргөжөөд байна. 2003-с 2014 онуудад ХасБанкны үе үеийн ажилтнуудын хандив, тусламжаар нийтдээ 815 сая төгрөгийн сан бүрдүүлж, 100 мянга гаруй хүүхэд залууст тэдний хөгжилд болон байгаль орчны санаачилгад дэмжлэг туслалцаа үзүүлжээ. ХасБанк нь 2009 оноос хойш хүүхдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрүүдэд 110 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсын ирээдүйн төлөө тууштай ажиллахаа нотлон харуулж байгаагийн илэрхийлэл юм. Одоогоор тус Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-ыг үндсэн долоон ажилтан сайн дурын үндсэн дээр удирдаж, дөрвөн туслах дэд баг, арван долоон ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2023 оны байдлаар Банкны ажилтнуудын 80 гаруй хувь нь Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-ын гишүүн болсон байна.

Тэмүүлэл хөтөлбөр

Төслийн зорилго

Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банк, Бичил санхүүгийн боломжууд байгууллагатай хамтран эхлүүлсэн “Тэмүүлэл” хөтөлбөр нь 12-18 насны хүүхдүүдэд хичээлийн цагийн дараа санхүүгийн боловсрол олгодог хөтөлбөр юм.

Үр дүн

- Өсвөр насны 120 хүүхдэд 3 цагийн санхүүгийн боловсрол олгох сургалт явуулсан.
- Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 40 сурагчдад санхүүгийн байгууллагуудтай танилцах аялал зохион байгуулсан.
- Ерөнхий боловсролын 5 сургуульд 1700 сурагч, 650 эцэг эхийг хамруулсан санхүүгийн боловсролын сургалт зохион байгуулсан.
- Ерөнхий боловсролын 5 сургуулийн бага ангийн 40 багшийг 2 хоногийн хугацаанд сургах “Сурагч Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.



Нийгмийн болон санхүүгийн боловсролын Афлатон хөтөлбөр

Төслийн зорилго

Афлатон хөтөлбөрийн зорилго нь 6-18 насны хүүхэд, залуучуудад нийгэм, санхүүгийн боловсрол олгох явдал юм. Манай сургалтын хөтөлбөр нь тэднийг өөртөө итгэлтэй, нийгмийн хариуцлагатай иргэн болоход нь тусалж төлөвшүүлдэг. Афлатон хөтөлбөр нь дундаа 4 жил тасалдсан тул бид 2023 онд шинэчилсэн хөтөлбөрөө туршилаа.



Үр дүн

- 2010-2014 онд 13,100 гаруй хүүхдүүд хамрагдав.
- Нийт 50 хүүхдийг хамруулсан 2 туршилтын сургалт зохион байгуулж сургалтын арга техникээ сайжруулсан.
- ХасБанкны 61 ажилтан оролцсон.



13,100
хүүхдүүд
хамрагдсан



50
хүүхдүүд шинэ
сургалтанд
хамрагдсан

61
ХасБанкны
ажилтан



Мод арчлах төсөл

Төслийн зорилго

“Тэрбум мод сан”-гийн аяныг дэмжих үүднээс бид хүүхдүүдийн эрүүл ногоон орчинд суралцаж, өсөх боломжийг нэмэгдүүлэх энэхүү төслийг эхлүүлсэн. Энэхүү төсөл нь залуу хойч үеийнхэнд мод арчлах, цэцэрлэг, сургуулийг ногоон байгууламжаар хангах, агаарын бохирдол, тоосжилтыг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа юм.

Үр дүн

ХасБанкны ажилчид, тэдний хүүхдүүд, сургуулийн багш, сурагчид нийт 12 байршилд 521 ширхэг мод тарив.



11 ЭЗЛЭЙ ХӨТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ

15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКО СИСТЕМИЙГ ХАМГАЛАХ

17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ



Арга хэмжээ

“Ирээдүйг дүү нартаа” хандивын аян



23.5
сая төгрөг

700
хүүхдүүдэд



Төслийн зорилго

ХасБанкны ажилтнууд шинэ хичээлийн жилд хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хувцас, ширээ, ном, сурах бичиг зэрэг хичээлийн хэрэгсэл хандивлалаа. Хас ТББ хандивыг сурагчийн цүнх, болон багц хэрэгслээр бэлтгэн хуваарилла.

Үр дүн

700 гаруй хүүхдүүдэд хандив хүргэгдсэн (21 аймагт болон Улаанбаатар хот)



“Мэргэжил сонгоход тань тусалъя”

Мэдээллийн технологийн мэргэжил

Хамтрагч

ХасBank мэдээллийн технологи (IT)

Зорилго

ХасБанкны ажилтны хүүхдүүдийн ажил мэргэжлийн хөгжлийн эхэн үеийг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн мэргэжилтэй холбоотой сургууль, ажлын туршлага, салбарын ирээдүйн чиг хандлага зэрэг сэдвүүд багтсан сургалт болсон.

Үр дүн

Ажилчдын 14-20 насны 50 хүүхэд сургалтад хамрагдав.

Гадаадад хэрхэн амжилттай суралцах вэ

Хамтрагч

Монголын НҮБ

Зорилго

Гадаадад суралцах хөтөлбөр, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар хүүхдүүдэд сургах.

Үр дүн

55 хүүхэд биечлэн болон цахимаар оролцсон.

Эрүүл мэнд, анагаах шинжлэх ухааны мэргэжил

Хамтрагч

АШУУИС

Зорилго

Хүний бие, түүний эрхтэн тогтолцоог ойлгохын тулд бид анагаах ухааны хэцүү атлаа сэтгэл ханамж өндөртэй карьерын талаар сургалт зохион байгуулав. Хүүхдүүдэд хими, биологийн хичээлийг бодит амьдрал дээр яаж хэрэглэгддэгийг харуулсан сургалт болсон.

Үр дүн

Сургалтад 15 хүүхэд хамрагдаж, 9 хүүхэд тус сургалтад хамрагдсаны дараа эмч болох хүсэлтэй болсон байсан.



Ном хандивлах аян



135 ном, **4.6** сая төгрөг хандивлав



Secret Santa



Төслийн зорилго

Үлгэрийн ном, малгай, бээлий, оймс, дархлаа дэмжих уламжлалт бүтээгдэхүүн, хүүхдэд зориулсан чихэр, жимсээр дүүргэсэн дахин ашиглах боломжтой бэлгийн уут.



100
ХҮҮХЭД

Үр дүн

Чулуун овооны Цангадавааны 100 гаруй хүүхдэд бэлэг гардуулсан.



Спортын сорилтууд



Төслийн зорилго

Биеийн тамирын дасгал сургуулилтаар дамжуулан ХасБанкны ажилтнууд гүйлт зэрэг төрөл бүрийн дасгалуудаар эрүүл мэндээ сайжруулав. Мөн залуучуудын багийн спортын тэмцээнийг ТББ-ын гишүүд, тамирчид дэмжлээ.

80
ажилтан

Үр дүн

- ХасБанкны биеийн тамирын дасгал сургуулилтад 80 ажилтан хамрагдсан.
- Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-ын гишүүд Идэрчүүдийн гар бөмбөгийн тэмцээн, орон нутгийн хөл бөмбөгийн тэмцээн, хүүхдийн мэтгэлцээний тэмцээн, Булган аймгийн 7 дугаар спортын их наадам, өсвөрийн сур харвааны тэмцээнд оролцсон.

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ДЭМЖИХ



ЗАСАГЛАЛ

Бизнесийн ёс зүй



Ёс зүй ба ёс зүйн хэм хэмжээ

ХасБанк нь бизнесийн үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах үүрэг хүлээсэн бөгөөд хувьцаа эзэмшигчид, захирлууд болон удирдлагын багийн манлайлал бүхий ёс зүйн соёлыг эрхэмлэн дээдэлдэг. Банкны ёс зүйн хэм хэмжээ, ашиг сонирхлын зөрчлийн талаарх бодлого нь үнэнч шударга байх, нэгдмэл байх, эрх тэгш байх, ил тод байх зарчимд суурилсан хамгийн шилдэг нь байх компанийн засаглалд суурилсан.



Авлига, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээнүүд

Хээл хахууль, авлигатай тэмцэх бодлого

ХасБанкны хээл хахууль, авлигатай тэмцэх бодлого нь хээл хахууль, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон удирдамж, журам юм. Энэхүү бодлого нь бидний бизнесийн үйл ажиллагааг үнэнч шударга, холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулах амлалтыг илэрхийлнэ. Энэхүү бодлогодоо авлигын эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга хэмжээ авах, бэлэг болон найрсаг, зочломтгой байдлын талаар баримтлах удирдамж, сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх журам, зөрчлийн үр дагаврыг тодорхойлсон. Шударга өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжиж, ёс зүйн хэм хэмжээг баримталж ил тод бизнесийн орчныг бүрдүүлэх зорилготой юм. Ажилтнууд, төлөөлөгч, түнш гээд хүн бүр ХасБанкны авлигын эсрэг бодлогыг дагаж мөрдөх ёстой.

Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам

Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны (insider trading) талаар баримталж буй бодлого нь байгууллагын ажилтан буюу хувь хүмүүс Банкны дотоод мэдээлэл, материалыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэхэд оршдог. Энэхүү бодлогод санхүүгийн зах зээлд нөлөөлөх давуу талтай мэдээлэлд үндэслэсэн үнэт цаасны арилжаанд тавих хязгаарлалтыг тодорхойлж тусгасан. Нийтэд хүрээгүй мэдээлэл (sensitive information) гэдэгт ажилтнууд тухайн компанийн хувьцааг арилжаалахыг хориглосон хугацаа, арилжаа хийх урьдчилан бүрдүүлэлтийн журам, болзошгүй зөрчлийг тайлагнах, шийдвэрлэх заавар зэрэг багтана. Ингэснээр зах зээлд шударга байдлыг хадгалах, арилжааны шударга ёсыг хангах, хөрөнгө оруулагчид болон олон нийтийн ХасБанканд итгэх итгэлийг бататгах зорилготой.

Мөнгө угаахтай тэмцэх бодлого

ХасБанкны Мөнгө угаахтай тэмцэх бодлого нь мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чухал тогтолцоо юм. Энэхүү бодлогод харилцагчийн мэдээллийг нарийн шалгах, санхүүгийн гүйлгээг хянах, сэжигтэй үйлдлийг холбогдох байгууллагад мэдээлэх асуудал хамаардаг. Цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр бид хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаагаа хууль бус санхүүгийн үйл үйлдлээс хамгаалж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх өргөн хүрээний хүчин чармайлтад хувь нэмрээ оруулдаг.

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод мөнгө угаах, ашиглан болон бусад хууль бус санхүүгийн үйл ажиллагаа зэрэг төрөл бүрийн санхүүгийн гэмт хэргийг шийдвэрлэх бүх үйл явц хамаарна. Тус бодлого нь санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулахад чиглэсэн стратеги юм. Энэ хүрээнд харилцагчийн үйл ажиллагааны техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хянан шалгах, гүйлгээг хянах, сэжигтэй үйл ажиллагааг тайлагнах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого нь манай эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд оршино.



Харилцагчийг таньж мэдэх бодлого

Харилцагчийг таньж мэдэх (KYC) бодлого нь эрсдэлийн удирдлага болон үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь харилцагчийн хэн болохыг шалгах, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлийг үнэлэх зорилготой. Харилцагчийг таньж мэдэхд үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр харилцагчийн тухай, тэдний санхүүгийн байдал, гүйлгээний мөн чанарын талаар сайн ойлгож үйлдлийг баталгаажуулна. Энэхүү бодлогод харилцагчийн мэдээллийг хууль ёсны эсэхийг шалгах, мөнгө угаах, залилан мэхлэх, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийн тулд харилцагчийн бичиг баримт, санхүүгийн түүх, бизнесийн уялдаа холбоо зэрэг холбогдох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа багтана. “Харилцагчийг таньж мэдэх” сайн бодлого хэрэгжүүлэх нь банкны харилцагчийн мэдээллийн санг бүрдүүлэхэд тусалдаг төдийгүй илүү найдвартай, ил тод санхүүгийн тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулдаг.



Харилцагчийн мэдээллийн хамгаалалт

ХасБанк нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдээллийн аюулгүй байдлын найдвартай арга хэмжээг хэрэгжүүлснээр харилцагчийн мэдээллийг хамгаалдаг. Эдгээр арга хэмжээнд хувийн болон дансны мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэхийн тулд төхөөрөмжийн хамгаалалт, хамгаалалттай файлууд, болон хяналтын камер бүхий барилга байгууламж багтана. Онлайн болон гар утасны үйлчилгээг Онлайн банкны аюулгүй байдлын нэмэлт хамгаалалтад хамруулдаг. ХасБанк нь бүтээгдэхүүний зүй зохистой дизайн, харилцагчийг өрийн дарамтанд орохоос урьдчилан сэргийлэх, ил тод байдал, үнэ тогтоох арга, харилцагчтай шударга, хүндэтгэлтэй харьцах, харилцагчийн мэдээллийн нууцлалыг хадгалах SmartCampaign баталгаажуулалтын стандартыг мөрддөг. ХасБанк нь гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх механизмтай бөгөөд бид хувийн мэдээлэл хулгайд өртсөн хохирогчдод залилан мэхлэлтийг таних, түүнээс зайлсхийх талаар мэдээлэл өгөх замаар туслаж байна. Түүнчлэн бид мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тухайлбал хууль эрх зүйн стандартад нийцсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартын талаар сүүлийн үеийн судалгаа хийх, мэдээллийн аюулгүй байдлын чадварлаг мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах зэрэг идэвх санаачилга гарган ажилладаг.



Шүгэл үлээгчийн хамгаалалт

ХасБанкны захирлууд болон ажилтнууд нийтийн ашиг сонирхлыг хохироосон эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдал эсхүл үйлдлээс зайлсхийдэг. Шүгэл үлээгчийн хамгаалалтын бодлого нь ёс зүйгүй эсхүл хууран мэхэлсэн үйлдлийг илрүүлэх, мэдээлэх, шийдвэрлэх үйл явцыг нууцлалтай хэрэгжүүлэх юм. Уг бодлогын тусламжтайгаар хууль тогтоомж зөрчсөн, банкны дотоод бодлого зөрчсөн, банкны хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг зүй бусаар ашигласан, ялгаварлан гадуурхсан, эрх мэдлээ хэтрүүлсэн, хүчирхийлэл дарамт учруулсан, мэргэжлийн алдаа гаргасан, хууль бус, ёс суртахууны хувьд буруутай үйлдлийг нуун дарагдуулсан аливаа үйлдлийг мэдээлэхийг дэмжинэ. Шүгэл үлээгч нь тусгайлсан цахим шуудангийн хаягаар эсхүл Компаенсийн ажилтанд биечлэн очиж нотлох баримтаа өгч, мэдээлж болно. Уг бодлогын дагуу мэдээлсэн этгээдийн нэрийг нууцлан хадгалж, мэдээллийг хүлээн авч, шалгалт явуулж буй хүмүүсийн нууцыг хамгаална. Шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг задруулсан эсхүл илгээсэн мэдээллийг задруулсан аливаа ажилтанд холбогдох шийтгэл ногдуулах бөгөөд энэ нь шүгэл үлээх үйл явцын аюулгүй байдал, нууцлалыг хангах талаар банкны хүлээсэн үүрэг амлалт болно.



Дотоод аудит

ХасБанкны ТУЗ-д шууд тайлагнах чиг үүрэг бүхий Ерөнхий Аудитор нь дотоод аудитын үйл ажиллагааг хариуцан ажилладаг бөгөөд Ерөнхий аудитор нь эрсдэлийн удирдлага, компанийн засаглал, дотоод хяналтын үр дүнтэй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Өдөр тутмын санхүүгийн гүйлгээ, зээлийн үйл ажиллагаагсанхүү, зээлийн удирдлагын нэгжүүд хариуцан ажилладаг бол аудитын үйл ажиллагаа нь нь газар дээр болон зайны хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй. Эдгээр нэгжүүд хамтран дотоод хяналтыг хэрэгжүүлж, ерөнхий үйл ажиллагаанд хяналт тавьж, гүйцэтгэлийг сайжруулах зөвлөмж гаргах замаар үйл ажиллагаанд бие даасан баталгаа гаргадаг. Түүнчлэн Дотоод аудитын нэгж нь Компаенсийн хэлтсээс ирүүлсэн ашиглан болон авилгатай холбоотой хэргийг шалгах ажиллагааг зохих журмын дагуу явуулдаг.



Утас:18001888, 75771888 (188)

Факс: 328701

И-Мэйл:info@хасбанк.mn

Хаяг: Улаанбаатар, СБД, Ерөнхий Сайд
Амарын гудамж, ХасБанкны Төв Байр,
ШХ 20А, Монгол